

“Бэрх Уул” ХК-ийн 2014 оны үйл ажиллагааны тайлан

Компанийн нэр: ”Бэрх Уул” ХК

Хаяг: Хэнтий аймаг, Бэрх тосгон (Батноров сум), Уулын үйлдвэрийн байр-01

Утас: 75859505, 99092755

Улсын бүртгэлийн дугаар:	1810002001
Регистрын дугаар:	2643928
Үйл ажиллагааны чиглэл:	Жонш, нүүрс олборлолт
Хувьцаа эзэмшигчдийн тоо:	108 /2015.03.13-ны байдлаар/

Үйл ажиллагааны тайлан:

Тус онд Чандганы нүүрсний уурхайд 120.000м³ хөрс хуулалтын ажил хийж 28,775 тн нүүрс олборлож Хэнтий аймгийн нүүрс хэрэглэгч байгууллагуудыг нүүрсээр хангасан. Энэ оны сүүлийн хагас жилийн халаалтын улирал эхлэхийн өмнө уулын техникүүдийг хэсэгчилэн засварласнаас Комацу 155А бульдозерын моторт их засвар хийсэн.

Дэлгэрхааны жоншны ордыг ашиглах Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж Монгол улсын эрдэс баялагийн зөвлөлөөр батлуулсан. Уг ордод цаашид үргэлжлүүлэн хайгуулын ажил, хуучин далд уурхайг ашиглах талаар судалгааны ажил хийж байгаа.

Мөн энэ онд тус компаний түүхт 60 жилийн ой тохиож түүнийгээ угтаж хийсэн хамгийн том ажил бол 2008 оноос ашиглахаа больсон Бэрх тосгонд байрлах компанийн хуучин ашиглаж байгаад орхисон 2 давхар 1500 м² талбай бүхий оффисийн барилгад их засвар хийж ашиглалтанд орууллаа. Уг засварын ажлын төсөвт өртөг 522 сая төгрөг байсан хэдий ч өөрийн ажилчидын хүчээр хийсэнээр барилгын засварт 200 сая төгрөг, тавилга эд хогшилд 93,7 сая төгрөг зарцуулж орчин үеийн тохилог оффисстой болцгоосон. Мөн ажиллагсдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулж хурлын танхим, фитнес, билярдын өрөө, мөн цайны өрөөг шинээр байгуулж иж бүрэн тохижуулсан.

Компаний нийт ажиллагсадын тоо 40, үүнээс гадаад мэргэжилтэн 1 хүн ажиллаж байна.

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд:

Компанийн 2012, 2013, 2014 оны жилийн орлогын тайлангийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2012 он	2013 он	2014 он
Борлуулалт	894.1	393.0	605.3
Борлуулалтын хөнгөлөлт	-	-	-
Цэвэр борлуулалт	-	-	-
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	579.2	339.0	491.9
Нийт ашиг	314.8	54.0	113.4
Үйл ажиллагааны бусад орлого	-	34.3	357.9
Үйл ажиллагааны зардалд	2,422.4	2,223.8	1661,7.
Үйл ажиллагааны бус ашиг /алдагдал /	193.9	(1,108.6)	(1190.4)
Үйл ажиллагааны бус зардал	-	2,014.4	3,471.2
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал /	(1,913.6)	(5,258.5)	(4,661.6)
Орлогын татварын зардал	-	0.10	108.06
Цэвэр ашиг /алдагдал /	(1,913.6)	(5,258.6)	(4,769.66)

Компани нь санхүүгийн тайлан балансыг хуульд заасан хугацаанд цаг тухайд нь гаргаж аж ахуй нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр болон нийгмийн даатгалын тайланг хуульд заасан цаг хугацаанд нь өгч, албан татварыг бүрэн төлж байгаа.

2014 оны байдлаар 28,775 тн нүүрс борлуулж 605,3 сая төгрөг, бусад орлого 357,9 сая төгрөг, нийт 963,2 сая төгрөгийн орлого олж, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 491,9 сая төгрөг, үйл ажиллагааны зардалд 1661,7 сая төгрөг, зээлийн хүүгийн зардалд 1223,0 сая төгрөг, валютын ханшийн зөрүүний алдагдалд 1236,0 сая төгрөг, мөн уурхайн нөхөн сэргээлтийн нөөц сангийн бууралт 1012,2 сая төгрөг, нийт 5624,8 сая төгрөг болж нийт (4661,6) сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Компани нь 2014 онд бүх татвар, нийгмийн даатгалын шимтгэлүүдийг цаг тухайд нь төлж байсан. Үүнд: НДШ -151,5 сая төгрөг, ААНОАТ-т 108,0 сая төгрөг, ХАОАТ-94,5 сая төгрөг, АМНАТ-21,0 сая төгрөг, Агаарын бохирдолын төлбөрт-13 сая төгрөг, Үл хөдлөх хөрөнгийн албан татварт-2,6 сая төгрөг, Суутгагчийн хувь хүнд олгосон суутгасан албан татварт-5,3 сая төгрөг, АТӨЯХАТ-0,7 сая төгрөг, Газрын төлбөр-1,2 сая төгрөг, нийт 397,8 сая төгрөг төлсөн.

Компанийн 2012 он, 2013 он, 2014 оны хөрөнгө, эх үүсвэрийн тэнцлийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

Хөрөнгө, өр төлбөрийн үзүүлэлтүүд	сая /төгрөгөөр /		
	2012 он	2013 он	2014 он
Эргэлтийн хөрөнгө	400.7	236.8	119.02
Эргэлтийн бус хөрөнгө	589.4	22,006.9	14,173.13
Нийт хөрөнгийн дүн	990.0	22,243.7	14,292.16
Богино хугацаат өр төлбөр	424.0	1,761.1	3,772.1
Урт хугацаат өр төлбөр	4,239.5	27,778.6	22,586.11
Эзэмшигчийн өмчийн дүн	(3,763.5)	(7,296.0)	(12,066.05)
Өр төлбөр, эзэмшигчийн өмчийн дүн	900.0	22,243.7	14,292.16

Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл:

Хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээд:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Нийт хувьцааны хувь
1	Khanate Resource Holding	51,8%
2	Khanate Resource Holdings-2 SARL	31,2%
3	BEU Holding S.A.R.L	10%
4	Khanate Resource Holding-3 SARL	6,6%
Нийт		99,6%

Үнэт цаас гаргагчийн ТУЗ, дэд хороодын мэдээлэл:

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Б.Батбаатар, Б.Мэндсайхан, Жэймс Пассин, Жэймс Флорес, Жимми Вайлд, Д.Даянбилгүүн, хараат бус гишүүдээр Б.Батхуяг, Б.Батмөнх, Д.Нарангоо, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б.Батбаатар, Гүйцэтгэх захирлаар Б.Мэндсайхан, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар Б.Пүрэвбаатар нар ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар 100 хувь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан.

Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга

№	Овог, нэр	Албан тушаал	Боловсрол
1	Бадан овогтой Батбаатар	ТУЗ-ийн дарга	дээд
2	Болд овогтой Мэндсайхан	ТУЗ-ийн ердийн гишүүн, Гүйцэтгэх захирал	дээд
3	Жимми Вайлд	ТУЗ-ийн ердийн гишүүн, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал	дээд
4	Жэймс Флорес	ТУЗ-ийн ердийн гишүүн, Санхүү эрхэлсэн захирал	дээд
5	Жэймс Пассин	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд
6	Данзан овогтой Даянбилгүүн	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд
7	Батболд овогтой Батхуяг	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
8	Батхүү овогтой Батмөнх	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
9	Дармаа овогтой Нарангоо	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
10	Баярсайхан овогтой Пүрэвбаатар	ТУЗ-ийн нарийн бичиг	дээд

Компани 2014 онд ногдол ашиг хувиарлааагүй бөгөөд их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлийг 2014 онд хийгээгүй болно.

Компани нь 2014 оны 04-р сарын 21-ны өдөр “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ыг зарлан хуралдуулж хурлын ирц 99,66% байсан.

ТУЗ-ын гишүүдийг дахин сонгосон бөгөөд 2014 оны 05-р сарын 21-ний өдөр ТУЗ-ийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх дэд хороодыг шинээр дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон:

а. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх аудитын хороог Б.Батмөнх, Жэймс Флорес, Д.Нарангоо гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Батмөнх -г томилсон.

б. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшуулалын хороог Жэймс Пассин, Д.Нарангоо, Б.Батмөнх гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Жэймс Пассин -г томилсон.

с. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороог Б.Батбаатар, Б.Батхуяг, Б.Батмөнх гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Нэр дэвшүүлэх хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Б.Батбаатар -г томилсон.

ТУЗ-с гаргасан тогтоол, шийдвэр түүний биелэлтийг өөрийн компанийн цахим сайтуудаар цахим хэлбэрээр явуулж тайлагнаж ажилласан.

Компани нь 2014 оны 04 сарын 21-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлуудыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2013 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2014 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2014 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

Компани нь 2013 оны 04 сарын 30-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлуудыг шийдвэрлэсэн.

1. ТУЗ-ийн гишүүд томилох
2. 2012 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланг батлах
3. 2013 оны бизнес төлөвлөгөө болон төсөв батлах
4. ТУЗ-ийн 2013 оны төсөв батлах
5. Компанийн хувьцааг хуваах тухай